



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/35

Булган сум

**Аймгийн тэшүүрийн аварга шалгаруулах тэмцээн  
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 19/08 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хишиг-Өндөр суманд тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд 5,000,000 (таван сая) төгрөгийг “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

